



МОНГОЛ УЛС  
ДОРНОД АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН 5-Р ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2017 оны 10 сарын 20 өдөр

Дугаар 10

Чойбалсан

“Нэг голын хүүхдүүд” төсөл батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2.ж/, 19 дүгээр зүйлийн 19.1, 25 дугаар зүйлийн 25.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4, Усны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Байгалийн унаган төрх, экологийн тэнцвэрт байдлыг хадгалан, хойч үедээ өвлүүлэн үлдээж, усны нөөцөө хамгаалах, хомсдолоос сэргийлэх, байгаль орчинд нийцтэй тогтвортой хөгжлийн бодлого хэрэгжүүлэх зорилтын хүрээнд хэрэгжих “Нэг голын хүүхдүүд” төслийг хавсралтаар баталсугай.

2. Төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган, хэрэгжилтийг ханган, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /М.Бадамсүрэн/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.ХИШИГТОГТОХ